**ХОНХОР ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН**

**ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛЫН ТАЙЛАН**

2025 оны 03 дугаар сарын 25 Улаанбаатар хот

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:**

**Өргөдөл, талархал, гомдлын төрөл**

| Д/д | Төрөл | Бодит тоо | Нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Нийт : | 10 | 100% |
| 1 | Талархал | 7 | 70% |
| 2 | Өргөдөл | 0 | |
| 3 | Гомдол | 3 | 30% |
| 4 | Хүсэлт | 0 | |
| 5 | Бусад | 0 | |

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт**

| Байгууллага нэр | Өргөдөл гомдлын тоо | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Бичгээр | 3Г-ын 11-11 төвөөр | 1800-1200 утсаар | Утсаар | Биечлэн | Бусад |
| Хонхор тосгоны эрүүл мэндийн төв | Өргөдөл | | | | | | |
| | Гомдол | | 3 | | | | |
| | Талархал | | 7 | | | | |
| | Хүсэлт | | | | | | |

**Өргөдөл, талархал, гомдлын агуулга**

| д/д | Төрөл | Өргөдөл гомдлын нийт тоо | Нийт өргөдөлд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1. | Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой | 3 | 30% |
| 2. | Эмч ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой | 0 | |
| 3. | Ажилтнуудын нийгмийн асуудалтай холбоотой | 0 | |
| 4. | Бусад | 0 | |

2024.01.01-2025.03.25-ны өдрийн хооронд Хонхор тосгоны эрүүл мэндийн төвд 11-11 төвөөр дамжуулан нийт 7 талархал ирсэн нь тус Эрүүл мэндийн төвийн их эмч Б.Бямбасүрэн, С.Хоролсүрэн, Д.Болормаа, Д.Даваадулам, эх барих бага эмч Т.Алтантуяа, вакцинатор Я.Туяацэцэг нарын мэргэжлийн ур чадвар, түргэн шуурхай найрсаг үйлчилгээ, ард иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах их үйлсэд сэтгэл зүрхээ зориулан ажилладаг тухай уламжилсан байна.

Тус эрүүл мэндийн төвд тайлант хугацаанд ЗГ-ын 11-11 төвөөс 3 иргэний гомдлын мэдээлэл ирсэн бөгөөд ирсэн гомдолын дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Үүнд эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой 3 гомдол ирсэнг хугацаанд нь шийдвэрлэсэн.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ХОНХОР ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Ө.ӨЛЗИЙПАГАМ

ТАЙЛАН БИЧСЭН:
АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН АЖИЛТАН Э.ЦЭРЭННАДМИД

Хонхор тосгоны эрүүл мэндийн
төвд өргөдөл гаргах нь.

Даваасүрэн овогтой Пүрэвсүрэн миний бие Баянзүрх дүүргийн 11-р хорооны ногоон зоорны 2-2 тоотод оршин суудаг.

Засгийн газрын харьяа 11-11 төвд 2025 оны 01 сарын 10нд эмийн жороо цахимаар авах боломжгүй байна гэж гомдол гаргасан. Гаргасан гомдлын дагуу Хонхор тосгоны эрүүл мэндийн төвийн дарга Ө.Өлзийнатан утсаар болон биечлэн уулзан 40 настай үйлчлүүлэгчид цахимаар хурууны хээ уншуулахгүйгээр эм бичиж олох боломжгүй гэдгийг тайлбарлаж ойлгуулсан. Иймд тухайн гомдол нь үндэслэлгүй байсан тул гаргасан гомдлоо буцааж байна.

Өргөдөл гаргасан

Иргэн Д. Пүрэвсүрэн / [signature] /

2025.01.14.

Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс

Хонхор тосгоны Эрүүл мэндийн төвд ирсэн G25025131 дугаартай

өргөдөл, гомдлын хариу тайлбар

2025.03.26 Улаанбаатар хот

2025 оны 03 сарын 25-ны өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Товчоо 5-121 тоотод оршин суугч иргэн С.Булганбаатар нь Хонхор тосгоны Эрүүл мэндийн төв Эрүүл мэндийн тусламж, үйл ажиллагаатай холбоотой гомдол гарсан байна. Тус гомдол нь манай Эрүүл мэндийн төв дээр 2025 оны 03 сарын 26-ны 09 цаг 09 минутанд шилжиж ирсэн. Үйлчлүүлэгчээс ирсэн гомдолтой унших танилцан Удирдлагын болон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын багийн хурал зарлан тухайн өдөр Түргэн тусламжийн дуудлагын ээлжийн эмчийг хуралд дуудан оруулж гомдол мэдүүлсэн дуудлагын талаар асууж, тодруулан болсон үйл явцын тухай хариу тайлбар гараар бичүүлэн авсан. Гомдол гарсан иргэн С.Булганбаатартай Эрүүл мэндийн төвийн дарга миний бие өөрөө утсаар холбогдон гомдлын талаар тодруулахад дараах асуудлаар гомдолтой байгааг хэлж цаашид давтан гаргахгүй байхыг хүслээ. Үүнд: Дуудлагаар очиж байгаа эмч нарын харилцаа хандлагыг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай шийдвэрлэж хүргэх, хэвтэн эмчлүүлэх тасгийн эмч орны зохицуултыг шийдвэрлэх талаар гомдолтой байсан гэв.

Түргэн тусламжийн дуудлагаар очиход үйлчлүүлэгч н.Саязан 84 настай, эрэгтэй Зүрхний архаг дутагдал оноштой. Зовиур: зүрхээр хатгуулж өвдөнө, цээжээр өвдөнө, гар бадайрч өвдөнө гэсэн зовиуртай байсан бөгөөд үзлэг БЕБ хүндэвтэр, орчиндоо харьцаатай, байрлал хагас суугаа, хэвтрийн. АД 120/70 мм муб, SpO2 - 95%, ЗЦТ 1 минутанд 95 удаа, биеийн халуун 36,5 хэм байсан байна. Эмч үзлэг хийн биеийн байдлыг ар гэрийхэнд тайлбарлахад эмнэлэгт заавал хэвтрүүлнэ гэсэн тул Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгрүү тээвэрлэн ЯТТ-ын тасагт хүргэсэн байна. Тус үйлчлүүлэгч 2025 оны 03 сарын 25-ны өдөр ЯТТ-ын тасгаар үзүүлээд буцсан бөгөөд эрчимт эмчилгээний тасагт хэвтээгүй одоогоор БЗД-ийн ЭМТ-д шинжилгээ өгч байгаа гэв. Үүний дагуу гомдол гаргагч хүү Булганбаатартай утсаар холбогдохдоо аавыгаа Хонхор тосгоны ЭМТ-д шууд авч ирэн хэвтүүлэх боломжтой гэдгийг хэлж ойлгуулав. Цаашид манай эмнэлэг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээндээ ахим ийм алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллан болно гэдгийг хэлэн, уучлалт гуйлаа. Гомдол гаргасан иргэн С.Булганбаатар гомдолгүй гэв.

Илтгэх хуудас бичсэн:

Хонхор тосгоны ЭМТ-ийн дарга Ө.Өлзийпагам

11-11 төвөөр орж ирсэн
гомдлын хариу тайлбар:

Хонгор Тосгоны Эрүүл Мэндийн Төвийн их эмч Д. Даваадулам нь 2025.03.25-нд жижүүрийн ээлжийн эмчээр ажиллаж байсан. Түргэн Тусламжаар 88252384 дугаарт 2025.03.25-нд 12 цаг 15 минутанд манай эмнэлэгт орж ирсэн дуудлагын дагуу тус айлд очсон. Цэрэн овогтой Баяраа 83 настай эрэгтэй, зүрхээр хатгуулж өвдөнө, цээжээр өвдөнө, гар бугуйгаар өвдөнө гэж зовиуртай байсан. Үзлэгээр: Биеийн ерөнхий байдал дунд, орчиндоо харьцаатай ухаан саруул, байрлал хагас суугаа, артерийн даралт 120/70 мм.муб. $SpO_2$-95% PS-95 $FiO_2$-0.2 t°-36.5, амьсгалын тоо -18, байсан. Үзлэг дууссаад үйлчлүүлэгчийн биеийн байдлыг ар гэрийнхэнд тайлбарлаж хэлэхэд заавал эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхээр байна гэж тул Баянзүрх Дүүргийн Нэгдсэн Эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт их эмч Халиунаад үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тайлбарлаж тээвэрлэж хүлээлгэж өгөв. Тухайн дуудлага дууссан.

тайлбар бичсэн: их эмч
Д. Даваадулам
94437070

2025.03.26